

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
06 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 – 8

- Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль,*
1. *тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

4 – 8

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 24-ний өдөр /Мягмар гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 79 гишүүн хүрэлцэн ирж, 62.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 01 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Х.Баттулга, П.Батчимэг, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Х.Жангабыл, Г.Лувсанжамц, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга;

Чөлөөтэй: Н.Алтаншагай, Б.Батцэцэг, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, Л.Энх-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Анар, Ж.Баясгалан, А.Ганбаатар, Д.Ганмаа, Л.Гантөмөр, Х.Ганхуяг, Т.Мөнхсайхан, Н.Наранбаатар, С.Одонтуяа;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Н.Алтанхуяг, Ж.Батсуурь, Г.Ганбаатар, С.Ганбаатар, Ч.Лодойсамбуу, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр, Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын референт Б.Төрбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны

хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгээс Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 1 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэв. /15:10/

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан уг асуудлаар 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 14.00 цаг хүртэл Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэгт завсарлага өгөв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Бүлгийн даргыг сонгосон тухай” Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс ирүүлсэн албан бичгийг уншиж танилцуулав.

Уг асуудлыг 15 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 12 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 94 гишүүн ирж, 74.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 13 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
15 цаг 01 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

77 гишүүн бүртгэгдэж ирц 61.1 хувьтай байна.

2025 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар нэг асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Гишүүдийг танхимд урья. Хэлэлцэх асуудалд орно.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатар танилцуулна.

Дүгнэлт бэлэн болоогүй байна уу? Б.Баярбаатар гишүүнийг дуудъя.

Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдаас 2025 оны 06 дугаар сарын 20-ны

өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд, холбогдох байнгын хороодод шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Нэг.Бусад Байнгын хороодоос ирүүлсэн санал, дүгнэлт:

1.Төсвийн байнгын хорооны санал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу Төсвийн байнгын хороо 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан байна.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Төсвийн байнгын хорооны гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлсэн.

2.Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлээс “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудал” гэснийг хасах, мөн хяналт тавих асуудал гэсний дараа “бүсчилсэн хөгжлийн бодлого” гэж нэмэх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол төслийн 1 дүгээр зүйлээс “хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал” гэснийг “хууль тогтоомж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал” гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй.

Мөн хамт өргөн мэдүүлсэн Засгийн газар дахь Хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлийг өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүдээс гарсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллийг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон анхны хэлэлцүүлэгт явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллийг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийн нэрийг танилцуулъя.

Гомбожавын Занданшатар Монгол Улсын Ерөнхий сайд, Сандагийн Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Болдын Жавхлан Сангийн сайд, Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга, Доржсүрэнхорлоогийн Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Бат-Эрдэнийн Төрбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын референт, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Нийт 17 гишүүн нэр ирүүлсэн байгаа. О.Цогтгэрэл дарга горимын санал гэсэн.

О.Цогтгэрэл: Их Их хурлын гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотой хуулийн өөрчлөлт дээр Ардчилсан намын бүлгээс ажлын 2 хоногийн завсарлага авахыг хүсэж байна.

Бас яг энэ асуудалтай холбоотой хэд хэдэн шалтгаан байна.

Засгийн газрын асуудал, бүтэц, бүрэлдэхүүний асуудал хэлэлцэж эхлэхээс өмнө Ардчилсан намын бүлгээс тодорхой хэмжээний зүйл, заалт бүхий шаардлагуудыг хүргүүлсэн. Энэ хүрээнд бид нарын хувьд бас дахин ярилцах, энэ асуудлын хүрээнд Байнгын хорооны хэлэлцүүлгийн явцад тоо баримтууд дээр дахин ярилцах шаардлагууд байна.

Бас нөгөө талаасаа Улсын Их Хурал гэдэг өөрөө ойлголцол, зөвшилцлийн талбар гэж бид бүгд ойлгож, асуудалд зөвийг зөв, буруу буруу гэж асуудалд хүндэтгэлтэй ханддаг.

Бас ингээд тодорхой хэмжээний хуулийн ойлголцол явж байгаа. Олон олон хуулиуд дээр өөр байр сууриуд бид нарт гарч байгаа учраас энэ дээр ойлголцол хэрэгтэй байна.

Мөн өнөөдөр бас Улсын Их Хурлын гишүүний, одоо бид нар бас тодорхой албан мэдээллүүд байхгүй байгаад байна. Улсын Их Хурлын гишүүний гэр, албан байр, олон зүйлүүд дээр хуулийн байгууллагууд дээр Ардчилсан намын бүлэгт хамаарах гишүүний хуулийн байгууллагуудаас хууль бус байж болох. Тэгэхдээ бид нарт тодорхой мэдээлэл одоогоор байхгүй байгаагаа бас дурдъя. Энэ шалгалтын ажлууд хийгдэж байгаа болохоор Ардчилсан намын бүлэг энэ хурлаас завсарлага авч.

Гол асуудал бол энэ бүтэц, бүрэлдэхүүний тухай хуультай бид нарт бас хэлэлцэх ярилцах зүйлүүд байгаа учраас Ардчилсан намын бүлэгт ажлын 2 өдрийн завсарлага өгөөч ээ гэж Их Хурлын даргад хэлье.

Д.Амарбаясгалан: 2 өдрийнх өө. Тийм.

Яах вэ, бид хэд уг нь энэ асуудлыг өнөөдөртөө багтаж хэлэлцэж дуусаад маргааш Засгийн газар энэ төсвийн тодотгол өргөн барих асуудлаа засгаараа шийдье гэсэн нэг ийм л төлөвлөгөөтэй ажиллаж байгаа юм л даа.

Өнөөдөртэй ойлголцож болохгүй юу? О.Цогтгэрэл дарга. Микрофон өгье.

О.Цогтгэрэл: Бид нар одоо бүлгийн хурал зарлаж хурал хийх л хэрэгтэй байна. Тэндээсээ бид нар асуудлаа л ярина.

Д.Амарбаясгалан: Ганц цагийн завсарлага аваад хоёр бүлэг хоорондоо уулзаад жоохон юм ярих уу?

2 өдрийн завсарлага гэхээр чинь одоо тэгээд 4 дэх өдрийн үдээс хойш хүртэл болно шүү дээ. 4 дэх өдрийн өглөө чуулган эхэлнэ. 2 цагийн завсарлага өгье.

Нэг өдрийн завсарлага өгье. Тэгэх үү. Маргааш өдөр 14.00 цаг хүртэл завсарлага өгье. Болж байна уу? Бидэнд цаг хугацаатай, яаралтай асуудал хэлэлцэж байгаа учраас олон өдрөөр завсарлага өгөх боломжгүй байгаад байна.

Тэгэхээр 25-ны өдрийн 14.00 цаг хүртэл Ардчилсан намын бүлэгт завсарлага өглөө.

“Бүлгийн даргыг сонгосон тухай” тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг.

“Бүлгийн даргыг сонгосон тухай”.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн бүлгийн ээлжит хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарыг бүлгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлж, хуралдаанд оролцсон гишүүдийн санал хураалтын дүнг үндэслэн Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн даргаар сонгосон болохыг мэдэгдье.

Хүндэтгэсэн бүлгийн дэд дарга А.Ариунзаяа гэсэн байна.

Тогтоолыг уншиж танилцууллаа.

Завсарлага өглөө. Маргааш 14.00 цагт чуулган үргэлжилнэ. Өнөөдрийн хэлэлцэх асуудал үүгээр дууслаа. /алх цохив/

Хуралдаан 12 минут үргэлжилж, 15 цаг 13 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД